



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 4/12

Дэлгэрхаан сум

**Анги дэвших болон улсын шалгалтын
комисс томилох тухай**

Боловсролын ерөнхий хуулийн 33-р зүйлийн 33.3.1, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2018 оны А/425 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ын 4.5, 4.6, 5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2024-2025 оны хичээлийн жилийн анги дэвших болон улсын шалгалтын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Б. Ариунчимэг /Сургалтын менежер/

Гишүүд: Х. Бямбасүрэн /БАЗАН/-ийн ахлагч

Д. Лхагважав /БУЗАН/-ийн ахлагч

Д. Энхчимэг /НУЗАН/-ийн ахлагч

Б. Үүрийнтуяа /Бага ангийн багш/

Б. Уранхайч /Математикийн багш/

Нарийн бичгийн дарга: Н.Оюундарь /Архив, бичиг хэрэг/

2. Шалгалтын хуваарь, шалгалтын дэг, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган мөрдөж ажиллах, шалгалтын дүнд анализ хийж, БНЗ-ийн хуралд танилцуулан шалгалтын мэдээг, хугацаанд нь Боловсролын газарт хүргүүлэхийг шалгалтын комиссын дарга (Б.Ариунчимэг)-т үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ш.ЦЭРЭНДУЛАМ